



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 10 өдөр

Дугаар А/37

Өвт

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 120 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Аймаг, нийслэл, сум, дүүргийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар”-ын 1.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Н.Бат-Эрдэнэ (Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд: Э.Дашдулам (Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн)

Б.Янжиндулам (Байгаль орчны хяналтын улсын байцаагч)

И.Маралмаа (Газрын даамал)

Л.Балжинням (Багийн Засаг дарга)

Д.Алтанцэцэг (Эрүүл мэндийн төвийн статистикч эмч)

Г.Сарантуяа (Архив, бичиг хэргийн эрхлэгч)

2. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, 2022 оны 03 дугаар 18-ны дотор батлуулахыг ажлын хэсгийн ахлагч (Н.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА С.АМГАЛАН



622101077

D:\My Doc A-4 zahiramj /Zasag darga/